



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
Д.САРАНГЭРЭЛ ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.07.05 № 01/5605  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Зөвлөмж хүргүүлэх  
тухай

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан албан хаагчид болон орон тооны бус шинжээч нар 2019 онд нэр бүхий аж ахуйн нэгжүүдээс "тусгай зөвшөөрөл"-ийн хүсэлт, төслийг хүлээн авч, шийдвэрлэхдээ удаа дараагийн үйлдлээр зохиомол хүнд суртал гаргаж хясан боогдуулах замаар хахууль өгөхөөс өөр аргагүй байдалд оруулж, хахууль авсан, 2018 оны 09 сард өөрсдийн хамаарал бүхий иргэний нэр дээр компани үүсгэн байгуулж, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрлийг хууль бусаар гаргуулж, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэх хэрэгт Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Авлигатай тэмцэх газраас дээрх гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тогтоох, дахин гарахаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилгоор 2019 оны 06 дугаар сарын 05-наас 14-ний өдрийн хооронд Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвд тусгайлсан удирдамжийн дагуу ажиллаа.


Ажиллах явцад Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв эрх, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулсан хуулийг дагаж мөрддөггүй, бодлогын баримт бичиг, журмыг хэсэг бүлэг хүмүүст тохируулан гаргадаг, удирдлагын зүгээс эрх олгох, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой салбарын өдөр тутамд гардаг хүндрэл бэрхшээлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал, чирэгдэл үүсгэгч шалтгаан нөхцөлүүдийг судлан тогтоох хүсэл эрмэлзэл, санаачлага байхгүй, хяналт тавьдаггүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ажлын байранд туршлагагүй, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдүүдийг томилсон, ажлын байрны тодорхойлолтыг албан хаагчид тохируулан боловсруулдаг, зөвшөөрөл олгох үйл явц, эрх зүйн баримт бичиг, зөвшөөрөл эзэмшигч нарын мэдээлэл ил тод биш зэрэг авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн шалтгаан нөхцөлийг тогтоолоо.

Иймээс Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу эрх олгох, тусгай зөвшөөрөл олгох үйл явцад гарч буй дээрх шалтгаан нөхцөлийг арилгах, цаашид дахин гарахаас сэргийлж, зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Хавсралт: Зөвлөмж 7 хуудас.

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА



**Зөвлөмж 1. Тусгай зөвшөөрөл олгох үе шатуудад зохиомол хүнд суртал чирэгдэл үүсгэж байгааг таслан зогсоох, зөвшөөрөл өгөх ажлыг түргэн шуурхай, үр дүнтэй, хяналт тавих, шат дамжлагыг бууруулах зорилгоор цахим систем нэвтрүүлэх;**

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох"-той холбоотой үе шат, бүрдүүлэх материал зэргийг тодорхой зохицуулж өгсөн байдаг. Тусгай зөвшөөрөл авах хоёр үе шатыг дамжихад цаг хугацаа их орох, аж ахуй нэгжүүд өөрийн байр талбайгүй, эсвэл баримт материал дутуу зэргээс хамаарч шийдвэрлэх хугацаа удаашралтай байдаг байна.

Ажлын хэсгийн зүгээс тусгай зөвшөөрөл авах хүсэлт өгсөн өдрөөс хойш шийдвэр гарах хүртэл нийт ажлын дарааллыг судлан үзэхэд 23-26 төрлийн ажил хийгддэг байна.

Эхний үе шат болох хэрэгцээний үнэлгээг яам ажлын 14 хоногийн дотор хийх боломжтой байдаг ч хуульд "120 хоногийн дотор" гэж зааж өгсөн тул яамны тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагчид тус үнэлгээг түргэн шуурхай хийдэггүй, мэдээлэл ил тод биш учир аж ахуйн нэгж байгууллагууд материалаа дутуу шаардлага хангахгүй хэмжээнд бүрдүүлдэг нь төслийг буцаах шалтгаан болж, хясан боогдуулах замаар хүнд суртал үзүүлдэг байсан байна. Улмаар аж ахуй нэгж байгууллагууд зөвшөөрлөө хурдан гаргуулахын тулд яамны албан хаагч нарт тал засах, хахууль өгөх байдлаар асуудлаа шийдвэрлүүлдэг жишиг тогтсон байна.

Хоёр дугаар үе шат болох ажлын байртай танилцаж дүгнэлт гаргах хөндлөнгийн ажлын хэсгийг яамны Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн даргын тушаалаар байгуулдаг боловч, дүгнэлт гаргах ажлын хэсгийг томилох ажил удаашралтай явагддаг байна. Уг үйл ажиллагаанд ажлын хэсэг томиллогдсон тохиолдолд ажлын байрны дүгнэлтийг гаргах ажил 1 хоногт багтаах боломжтой байна. Одоо хариуцаж байгаа ажилтан Ш.Энхзаяа ажлын хэсгийг томилох, ажлын байртай танилцах ажлыг ажлын 5-7 хоногт гүйцэтгэх боломжтой талаар танилцуулсаж байсан.

Өмнө нь уг шат дараалал удаан байсан тул аж ахуйн нэгж байгууллагууд хахууль өгөх замаар асуудлаа түргэн шуурхай шийдвэрлүүлэх хандлага их байна. Иймд цаашид хүний оролцоог багасгах замаар авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал чирэгдлээс сэргийлж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлэх, хяналтын зөв тогтолцоо бүрдүүлэх нь зүйтэй байна.

**Зөвлөмж 2. Хөндлөнгийн шинжээчдийг судалж авах, дүгнэлт гаргахын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай маягт бөглүүлж, үйл ажиллагаанд хяналт тавих.**

Аж ахуй нэгжүүдийн зүгээс асуудлаа түргэн шуурхай шийдвэрлүүлэх зорилгоор хахууль өгөх хүсэл сонирхол өндөр байна.

Тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуй нэгжүүдийн дийлэнх нь өөрийн гэсэн байр талбайгүй байдаг ба Эрүүл мэндийн яамнаас томилогдсон шинжээч нар ажлын байртай очиж танилцахад өөр аж ахуй нэгжийн байр, талбайг танилцуулах, эсвэл стандартын шаардлага хангахгүй байртай байдаг байна. Иймээс аж ахуй нэгжүүд ЭМЯ-аас томилогдсон хөндлөнгийн гэх шинжээч нарт хахууль өгч байр талбайн хувьд зөрчилгүй, хэвийн гэсэн дүгнэлт гаргуулдаг байна. Хөндлөнгийн шинжээч нар нэгэн зэрэг олон материал судлан танилцдаг тул ихэвчлэн биечлэн очиж үзэлгүйгээр дүгнэлт гаргасан тохиолдол цөөнгүй байна.

Хөндлөнгийн шинжээч нарын үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн дотоод хяналт огт байхгүй байгаад цаашид анхаарч шийдвэрлэх шаардлагатай байна.

**Зөвлөмж 3. Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын загвар боловсруулж, тус ажлын байранд тохирох мэргэжил, ур чадвар, мэргэшсэн байдал зэргийг тусгаж, Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн батлах, цаашид уг ажлын байранд мэргэжил, ур чадвар, ажлын туршлагагүй иргэнийг ажилд авахгүй байх.**

Тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагчид АТГ-т шалгагдаж байгаатай холбогдуулан ЭМЯ-д өмнө ажиллаж байсан болон шинээр томилогдон ажиллаж байгаа албан хаагчдийн мэргэжил, ажлын туршлагатай танилцахад Эрүүл мэндийн яам тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлахдаа ажилтны хувийн байдалд тохируулан тухай бүр шинэчлэн баталдаг байна.

Тус яам өмнө нь тусгай зөвшөөрөл хариуцаж байсан хоёр албан хаагчийг анх томилоход мөн адил ажлын байрны тодорхойлолтыг хувь хүнд нь тааруулж батлуулсан байх бөгөөд нарийн мэргэжил, ур чадвар шаардсан, хариуцлагатай ажлын байранд зөрчил дутагдал, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн яамны удирдлагын зүгээс онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Тухайлбал; Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байр, албан тушаалын тодорхойлолтыг дараахь байдлаар өөрчилсөн байна.

Албан тушаалд тавигдах тусгай шаардлага хэсэгт Мэргэжил: их эмч гэж байсныг Эрүүл мэндийн салбарын аль нэг мэргэжилтэй байх гэж өөрчилсөн. Туршлага: Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх, төрийн жинхэнэ албан хаагч байх гэж заасныг туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх гэж өөрчлөн тус ажлын байранд Анагаах ухааны их сургуулийг хүний эмч мэргэжлээр 2016 онд төгссөн, яамны олон нийттэй харилцах ажил хариуцаж байсан, Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой ажлын туршлагагүй, төрд 2.3 жил ажиллаж байгаа Н.Отгонжаргалыг томилсон байна.

**Зөвлөмж 4. Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийт танилцах боломжоор хангах.**

Тусгай зөвшөөрөл авах, сунгах үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүд ил тод биш байна.

Тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай мэдээллийн жагсаалт, ямар хууль, дүрэм, журмын дагуу зөвшөөрөл авах ёстой талаар албаны цахим хуудас болон мэдээллийн самбарт байдаггүй тул үйлчлүүлэгч аж ахуйн нэгжүүд баримт материал дутуу бүрдүүлж олон дахин ирэх зэргээр хүндрэл учирдаг байна.

Яамны <http://www.mohs.mn> цахим хуудсанд хандахад тусгай зөвшөөрлийн цэс байхгүй, тусгай зөвшөөрөл хүсэгч иргэн, аж ахуйн нэгж ямар материал бүрдүүлэх талаар болон тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой ямар ч мэдээлэл байхгүй. Яамны нэг давхарт байх хүлээн авах хэсэгт тусгай зөвшөөрөл хүсч буй иргэн, аж ахуй нэгжээс холбогдох мэдээллийг авах ямарч боломж бололцоо байхгүй болох нь яаманд ажиллаж байхад ажиглагдаж байлаа.

Мэдээлэл авах нөхцөл боломж бүрдээгүйгээс яамны албан хаагч нарт тал засах, танил талаараа дамжуулж мэдээлэл авахаас өөр арга байдаггүй талаар зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл хэлж байв.

Эрүүл мэндийн яам үйл ажиллагаа явуулах чиглэлийн тусгай зөвшөөрлийг Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д заасны дагуу одоог хүртэл нийтэд ил тод болгоогүй байгаа нь авлига гарах эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

Иймд Эрүүл мэндийн хөгжлийн төв Лайсмэд програм нэвтрүүлж эм зүйн чиглэлээр олгодог тусгай зөвшөөрлүүдийг хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн нэр, утас, хаяг, зөвшөөрөл авсан огноо, дуусах огноо зэрэг мэдээллийг ил тод байршуулсан зэрэг туршлагыг судалж, үйл ажиллагаандаа хэвшүүлэх шаардлагатай байна.

#### **Зөвлөмж 5. Албаны ёс зүй, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, хариуцлага тооцох тогтолцоог бие болгох.**

Эрүүл мэндийн яамны үйлчилгээ болон төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, мэдээллийн бүртгэл, шийдвэрлэлтийн тогтолцоо оновчтой бус Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөл байгуулагдаагүй, албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр баталгаажуулаагүй, төрийн албаны салбар зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хороог 2012 оноос хойш 7 жилийн хугацаанд өнөөдрийг хүртэл байгуулаагүй ажиллаж байна. Эрүүл мэндийн яаманд төрийн захиргааны албан хаагчидтай холбоотой өргөдөл, гомдол мэдээллийг хянан шалгах Төрийн албаны дэргэдэх Ёс зүйн хороо, зөвлөл байгуулж ажиллаагүйгээс яамны албан хаагчдын ёс зүйтэй холбоотой зөрчил их гардаг, мөн хаана хандаж гомдол гаргах, хэрхэн шийдвэрлэснийг хянах боломжгүй байна. Үүнээс үүдэн тусгай зөвшөөрөл олгодог мэргэжилтнүүдээс гадна бусад албан хаагчид авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдалд орох эрсдэлд орсон байна.

Төрийн албаны зөвлөлөөс "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ыг батлан мөрдүүлж байгаа бөгөөд дүрмийн зорилго нь ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагчийн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад чиглэгддэг. Тус журмаар байгууллага бүр ажилтны тооноос хамааран өөрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган тогтоох, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын болон орон тооны бус Ёс зүйн хороотой байхаар заасан байдаг. Гэтэл тус яам 2012 оноос хойш ёс зүйн хороог байгуулаагүй нь төрийн захиргааны албан хаагч нарт хариуцлага тооцохгүй байх нөхцөлийг бүрдүүлж, улмаар авлига ашиг сонирхлын зөрчилд холбогдох, авлигын гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөл болсон байна.

Иймд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Төрийн байгууллагын удирдлага нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх" үүргээ биелүүлж, ёс зүйн хороог хууль журмын дагуу байгуулан тогтмол ажиллуулах шаардлагатай байна.

Салбарын хэмжээнд зөвхөн судалгааны чиглэлээр хяналтын ёс зүйн хороо, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо ажиллаж байна.

**Зөвлөмж 6. Эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоод хяналт шалгалтыг тогтмол хугацаанд хийх.**

Эрүүл мэндийн яам тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг бичиг хэргийн ажилтнаар дамжуулан авах ёстой боловч бичиг хэргийн ажилтан болон бүртгэлийн програмд бүртгүүлэлгүйгээр тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагч нар өөр дээрээ шууд авч удирдах албан тушаалтнуудад танилцуулалгүйгээр тусгай зөвшөөрөл олгосон тохиолдлууд байна. *Тухайлбал: Timus pharma ХХК-ийн хүсэлтийг тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн хүлээн авч удирдах албан тушаалтанд танилцуулалгүйгээр 4 төрлийн зөвшөөрөл олгосон тохиолдол байна.*

Аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн хэдэн нь бичиг хэргээр дамжсан, хэд нь бичиг хэргээр дамжилгүйгээр зөвшөөрөл авсан тохиолдол байгаа талаарх мэдээллийг нарийвчлан гаргах гэсэн боловч тус яам 2009 оноос хойш Лотус гэх бичиг хэргийн програмыг ашиглаж байгаад 2019 онд АБЛЕ гэх шинэ програм нэвтрүүлэхдээ уг хоёр програм дахь мэдээллийг шилжүүлэхэд зарим мэдээлэл устгагдсан, өмнө нь бүртгэж байсан бичиг, баримтын мэдээллийг харж, шийдвэрлэлтэд хяналт тавих боломжгүй болсон байна. Энэхүү хариуцлагагүй байдлыг таслан зогсоож, буруутай этгээдэд хариуцлага тооцох, архив, бичиг хэргийн үзлэг шалгалт явуулах шаардлагатай байна.

Түүнчлэн өргөдөл, гомдлын утга, агуулгыг ангилж бүртгэдэггүй, шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл гардаггүй тул өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих боломжгүй байна.

**Зөвлөмж 7. Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг бодит түвшинд тодорхойлох, зөвшөөрөл олгох шаардлагатай, шаардлагагүй чиглэлийг оновчтой тодорхой болгоогүй байна.**

Зах зээлийн эдийн засагт эрэлт ба нийлүүлэлтийн эдийн засгийн хатуу хууль үйлчилдэг ба хэрэглэгчийн худалдан авах чадвараар баталгаажсан хэрэгцээг эрэлт гэдэг. Эрэлт их үед бараа бүтээгдэхүүний үнэ өсөх, хомсдолд орох зэрэг хүндрэл үүсдэг. Харин худалдагчийн зах зээл дээр барааг худалдах хүсэл, чадварыг нийлүүлэлт гэдэг. Нийлүүлэлт их үед бараа бүтээгдэхүүний борлуулалт, чанар муудах зэрэг эрсдэл үүсдэг тул эрэлт нийлүүлэлтийг тэнцвэртэй байлгах нь чухал байдаг.

Энэ ч үүднээс хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах салбарын эм, эрүүл мэндийн байгууллагын эрэлт хэрэгцээг нарийн тодорхойлох шаардлагатай ба Эрүүл мэндийн тухай хуульд 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т зааснаар "Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг гурван жилийн хугацаагаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно." гэж зохицуулсан байна.

Өнөөгийн байдлаар эрүүл мэндийн салбараас олгож буй эрх олгох, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцаанд зөвшөөрөл хүссэн, шаардлага шалгуур хангасан гэх аж ахуйн нэгж бүрт зөвшөөрөл олгож байна. Жилд хэдэн тусгай зөвшөөрөл олгох талаар хязгаарлалт тавьсан бодлогын баримт бичиг судалгаа байхгүй, зөвхөн тэргүүлэх чиглэл гэж гаргасан ба дараах хүндрэл үүссэн байна. Тухайлбал;

1. Эрүүл мэндийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн "Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл батлах тухай" А/421 дүгээр тушаалаар батлагдсан эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл /2018-2020 он/-ийн хүрээг улсын хэмжээнд ерөнхий гаргаж, тусгай зөвшөөрөл

олгохгүй чиглэлийг тодорхой болгоогүйгээс тусгай зөвшөөрлийн талаар баримталж буй бодлого чиглэлтэйгээ тусгай зөвшөөрлийн комиссын шийдвэр нийцэхгүй байна гэж үзэж байна. Тухайлбал; Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 8 дахь бодлогын чиглэлийн 2.4.8.3-т заасан "эрүүл мэндийн байгууллагыг шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэхдээ хүн амын тоо, газар зүйн байршил, нутаг дэвсгэрийн онцлог, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, судалгаанд тулгуурлан зохион байгуулах" гэж заасан байдаг.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл /2018-2020/ -ийн нийтлэг үндэслэлийн 4-т Эрүүл мэндийн тухай хуулийн 19.5.1-д заасан эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа шинээр эрхлэх тохиолдолд сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгох зохицуулалт хэрэгжээгүй байгаа нь ашиг сонирхлын зөрчил гаргасан гэж үзэхээр байна. Учир нь энэхүү сонгон шалгаруулалт нь тендерийн сонгон шалгаруулалт бус энгийн уламжлалт худалдан авалтын аргаар хийгдэх тул тусгай зөвшөөрлийн тэргүүлэх чиглэлд заасан нэн тэргүүнд тусламж, үйлчилгээ тасалдаж байгаа сувилахуйн дагнасан болон сэргээн засахын тусламж, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагааг эрхлэх байгууллагыг дүүрэг, аймаг, сумдад байгуулахаар сонгон шалгаруулалт зарлах боломжтой байсан зэргийг хэрэгжүүлээгүй байна.

3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 12.5-д "сувилахуйн болон хөнгөвчлөх асаргаа, сувилгааны төв байгуулах журам, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа, сувилгааны төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт" болон 13.5-д "Сэргээн засах төв, сувилал байгуулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам болон сувилал, сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт"-ыг тус тус эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар эрх олгосон байтал хууль даган гарах журам гараагүй байна.

**Зөвлөмж 8. Тусгай зөвшөөрөл олгох ажлыг эрүүл мэндийн салбарын мэргэжлийн нийгэмлэг, холбоо төрийн бус байгууллагад шилжүүлэх.**

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7-д "Хэрэгцээний үнэлгээг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас сонгон шалгаруулсан мэргэжлийн нийгэмлэг, холбоо гүйцэтгэнэ." гэж заасан боловч одоог хүртэл тусгай зөвшөөрөл олгох ажлыг төрийн бус байгууллагад шилжүүлээгүй, шилжүүлэх ажлыг эхлүүлээгүй байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 19.29-д заасан журмын төсөлд улсын хэмжээнд хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг 3 жил тутам үнэлж, эрүүл мэндийн байгууллага шинээр байгуулах төлөвлөлт хийхээр зохицуулсан. Эрүүл мэндийн тухай хуулийн 19.7-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Журам, шалгуур үзүүлэлт батлах тухай" А/25 дугаар тушаалын дагуу хэрэгцээг үнэлэх төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоог сонгон шалгаруулж, гүйцэтгүүлэх талаар зохицуулсан байдаг ч энэ талаар одоог хүртэл ямар нэг ажил хийгдээгүй байна.

**Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс олгож буй эрх олгох үйл ажиллагаатай танилцахад дараах эрсдэлүүд байна.**

**Зөвлөмж 9. Төгсөлтийн дараах сургалт буюу резидентийн сургалтын эрх авах үйл явц дахь авлигын эрсдлийг таслан зогсоох.**

Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалт буюу резидентэд суралцахад төрөөс сургалтад оролцогч нарын зардлыг санхүүжүүлэх эвсэл суралцагч өөрөөсөө сургалтын зардлыг гаргах гэсэн санхүүжилтийн хоёр

төрөлтэй байна. Хэрэв төрөөс зардлаа даалгах бол аймгийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас жил бүр олгодог квотод багтах ёстой байдаг байна.

Элсэгчдийн хувьд танил тал, эсвэл албан тушаалтнуудад хахууль өгөх замаар аймаг, нийслэлийн квотод орох сонирхол өндөр байдаг байна. Хэрэв тус квотод багтаж чадвал шалгалтад 70 хувиас дээш оноо авсан тохиолдолд бусад оролцогч нараас бага оноо авсан ч резидентэд суралцах эрхийг албан бусаар өгдөг зохион байгуулалтад 2013 оноос хойш орсонтой холбоотой байна. Уг шалтгаанаар сурагчийн хувьд аймаг, нийслэлийн квотод багтах сонирхол өндөр байдаг байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ын 15 дугаар зүйлийн 15.17.1-д "...элсэлтийн шалгалтын дүн хүчингүй болсон тохиолдолд мэргэшүүлэх сургалтад элсүүлэхгүй бөгөөд элсэлтийн хяналтын тоонд багтаан онооны дарааллаар шалгалтад тэнцсэн дараагийн мэргэжилтнийг элсүүлж, нэрсийн жагсаалт гаргана" гэж заасан ба аймаг, нийслэлийн квотод багтасан элсэгч бусад элсэгч нараас бага оноо авсан бол давуу эрх эдэлж, шалгалтад тэнцэх талаар зохицуулалт байдаггүй.

Өөрөөр хэлбэл Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төв уг шалгалтыг зохион байгуулах, сургалтын эрх олгохдоо 2013 оноос хойш хууль бусаар шалгалтад хангалтгүй, бага оноо авсан элсэгч нарыг аймаг, нийслэлээс суралцах хүсэлттэй тул давуу байдал олгосон гэсэн үг юм.

Их эмчээр төгсөж мэргэжил дээшлүүлэх хүсэлттэй иргэдийн хувьд эрүүл мэндийн салбарын төрийн байгууллагад танил талгүй, эсвэл албан тушаалтнуудаар нөлөөлүүлж аймаг, нийслэлийн квотод багтаж чадахгүй бол улсын санхүүжилтээр суралцах боломжгүй, шалгалтаар хамгийн өндөр оноо авч өөрийн зардлаар суралцах сонголт үүсдэг байна. Энэ байдлаас хархад шалгалтад хамгийн өндөр оноо авсан элсэгч өөрийн зардлаар, аймаг, нийслэлийн квоттой бага оноо авсан элсэгч улсын санхүүжилтээр сурч, төгсөөд ажлын байртай болдог шударга бус тогтолцоо төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад харагдаж байна.

**Зөвлөмж 10. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийг журам зөрчиж зохион байгуулдаг, шалгалт өгөөгүй иргэнийг тэнцүүлсэн зөрчил байна. Тус зөрчлийг дахин гаргахгүй байхад анхаарч, шалгалт зохион байгуулах журмыг шинэчлэх.**

Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалт шударга, ил тод, нээлттэй зохион байгуулагддаггүй байна. Тухайлбал;

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын 2018 оны А/132 дугаар тушаалаар төгсөлтийн дараах сургалтад элсэх элсэлтийн шалгалтыг 2018 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр, 2018 оны А/135 дугаар тушаалаар 2018 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр дахин авсан байна. Уг элсэлтийн шалгалтын үеэр дараахь зөрчлүүд гарсан байна. Үүнд:

1. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалтын хоёр дахь шалгалтын А, В, С, D вариантын сорил шалгалтын өмнөх өдөр задарч хоёр дахь шалгалтад орсон их эмч нар олноор тэнцсэн. Шалгалтын сорилыг бусдад дамжуулж зарсан гэх маргаан үүссэн.

2. Зөрчилтэй иргэдийг шалгалтад оруулсан. Жишээ нь "Дүрс оношилгоо судлал" мэргэжлээр шалгалт өгсөн Б.Болортуяагийн "хүний их эмчийн дипломын хуулбар" хуурамч, "Дүрс оношилгоо судлал" мэргэжлээр резидентийн шалгалт өгсөн

Т.Онолбаяр нь 2018 онд өөр мэргэжил буюу "Уламжлалт анагаахын их эмч мэргэжилтэй байна.

3. Шалгалтад өгөөгүй их эмч нарыг шалгалтад тэнцүүлдэг. Жишээ нь:

Ач анагаахын их сургуулийг 2018 онд хүний их эмчээр төгссөн Б.Туулайхүү нь 2018 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр, 2018 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр дахин авсан шалгалтуудад ороогүй ба 2018 оны 8 дугаар сарын 13-наас 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд Бүгд найрамдах Кенн улсад зорчиж байсан байна. Шалгалтын материалтай танилцахад бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн, шалгалтад оролцогч нарын гарын үсгийг дурайлган зурсан байна.

Улмаар Б.Туулайхүү нь тус шалгалтад тэнцэж, улсын 3 дугаар төв эмнэлэгт хуваарилагдан "мэс засал"-ын чиглэлээр төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдсан байна.

4. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн шалгалтын хурлын тэмдэглэлүүдэд шалгалтын комиссын дарга А.Амарсайхан, нарийн бичгийн дарга Г.Цолмонбаяр гэсэн хоёр хүний гарын үсэг байх ба шалгалтыг газар дээр нь авсан комиссын гишүүдийн гарын үсэгтэй шалгалтын тэмдэглэлүүд байхгүй байна.

Хүний нөөцийн бодлого зохицуулалтын албаны дарга, шалгалтын комиссын дарга Б.Амарсайхан нь тус төвөөс 2018 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр чөлөөлөгдсөн тул 2018 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн дахин шалгалтын комисс даргагүйгээр шалгалтын ажил зохион байгуулсан, хурлын тэмдэглэлд шалгалтын бусад гишүүдийн гарын үсэг байхгүй зэрэг зөрчлүүд байна.

Эдгээрээс харахад Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалтыг хяналт сул зохион байгуулдаг тул албан хаагч нар авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэй нөхцөл байдал үүсэн байна.

**Зөвлөмж 11. Албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхгүй байж, тухай бүр Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх.**

Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалтын үеэр төрийн өндөр албан тушаалтан, салбарын удирдах албан тушаалтнуудаас 2018 онд ЭМХТ-ийн даргад нийт 25 цохолттой албан бичиг, хүсэлт ирсэн байна. Хүсэлтэд эмнэлгийн ажилтан, эмчийн нэрийг бичиж төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад элсэгчийг төсвийн санхүүжилтэд хамруулах, шалгалтад тэнцүүлж, суралцахад дэмжиж өгөх тухай асуудлыг тусгасан байна.

Энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасан "албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх"-ийг хориглоно гэснийг зөрчсөн агуулгатай байна. Өөрөөр хэлбэл төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалтад оролцох хүсэлттэй их эмч Эрүүл мэндийн хөгжлийн төв болон харьяа байгууллагад гаргасан хүсэлтийн дагуу шалгалтад оролцох эрх нээлттэй байхад Улсын Их Хурлын гишүүн, харьяа нутаг дэвсгэрийн Засаг дарга, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын дарга гэх мэт албан тушаалтнуудаар дамжуулан төсвийн санхүүжилтэд хамрагдах, шалгалтад тэнцүүлэх зэргээр албан бичиг, хүсэлт хүргүүлж байгаа нь тус шалгалтыг зохион байгуулж байгаа нэгжид хөндлөнгөөс нөлөөлөх замаар бусдаас давуу эрх эдлэх сонирхолтойг харуулж байна.